

СЭЗИС-д элсэхийг хүсэгчдэд зориулсан эсээ бичих удирдамж

Санхүү Эдийн Засгийн Их Сургуульд элсэхийг хүсэгч нь өөрийн суралцах бэлтгэл (сурлага), авъяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлсэн эсээ бичиж элсэлтийн комисст цахим хэлбэрээр 2019-06-25 өдрийн 18:00 цагаас өмнө элсэлтийн бүртгэлийн системээр илгээсэн байна. Эсээ элсэгчийн өөрийн бүтээл байна.

Элсэхийг хүсч буй сурагч бүр өөр хоорондоо харилцан адилгүй, давтагдашгүй, онцгой байдаг. Таны сонирхол, бүрэн дунд боловсрол эзэмшсэн байдал, давуу болон сул тал, ирээдүйн зорилго тус бүрдээ ялгаатай тул элсэхийг хүсэгчдийн онцгой, давтагдашгүй байдлыг сонгон шалгаруулах комиссын гишүүд эсээгээр дамжуулан баримжаалдаг. Иймээс эсээ нь СЭЗИС-д элсэхийг хүсэгчид өөрийгөө илэрхийлэн харуулах боломж юм. Та өөрийн эсээндээ хэн болохоо, яагаад СЭЗИС-ийг сонгосон, таны хувьд юу чухал байдаг, ямар зорилготой, түүндээ хэрхэн хүрэхээр төлөвлөж байгаа талаараа бичээрэй.

Үгийн тоо: 500-600

СЭЗИС-д элсэхийг хүсэгчдийн эсээг үнэлэх шалгуур:

	Шалгуур	Тайлбар
1	Эсээний зорилго	Эсээнд СЭЗИС-ийг сонгосны учир, шалтгааныг өгүүлж, өөрийгөө илэрхийлж чадсан эсэх
2	Эшлэл хийх	Өөрийн санааг тодруулах, дэмжих, батлахын тулд бусдын бүтээлээс ашиглахдаа зохистой хэмжээгээр ашигласан эсэх
3	Эсээний бүтэц	Өөрийн санааг илэрхийлэхдээ мэдээллийн дэс дарааллыг зөв, оновчтой гаргаж буй байдал
4	Хэл найруулга	- Үг, хэллэгийг оновчтой сонгосон байдал - Нөхцөлийг зөв ашиглаж буй байдал - Учир шалтгааны алдаагүй байх
5	Зөв бичих дүрэм	- Дүрмийн алдаагүй байх - Цэг, тэмдэг, хашилт, хаалтыг зөв хэрэглэх